МЭДЭЭ · 2023 оны 6-р сарын 8

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ЭРГҮҮЛИЙН ОФИЦЕРУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



Баянгол дүүргийн прокурорын газраас дүүргийн Цагдаагийн газрын эргүүлийн офицеруудад "Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн онцлог, шалгах ажиллагааны явцад анхаарах асуудал"-ын талаар сургалт явуулжээ.

Тодруулбал, сүүлийн жилүүдэд тус дүүрэгт Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралт нэмэгдэж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор Цагдаагийн байгууллагын алба хаагчдын зүгээс хүчирхийллийн улмаас хохирсон иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ болон холбон зуучлах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор тус сургалтыг зохион байгуулсан байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1912